



**ХӨВСГӨЛ АЙМГИЙН  
БАЯНЗҮРХ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2024 оны 02 сарын 14 өдөр

Дугаар А/15

Алтлага

Ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх  
тэмцэх ажлыг эрчимжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, "Ойн тухай хууль"-ийн 18 дугаар зүйлийн 18.2.5, 18.2.10, 18.2.13-д заасныг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Улсын онцгой комиссын 2021.03.01-ний өдрийн 02 тоот албан даалгаврын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг сумын Засаг даргын Тамгын газрын дарга, онцгой байдлын орон тооны бус штабын даргад даалгасугай.

Хоёр. Багийн Засаг дарга нарт ДААЛГАХ нь:

2.1 Ой хээрийн түймэр гарах байгалийн нөхцөл бүрдсэн хуурайшилт бүхий цаг хугацаа буюу хавар 3 дугаар сарын 20-ноос 6 дугаар сарын 10-ны өдөр, намар 9 дүгээр сарын 20-ны өдрөөс 11 дүгээр сарын 10 хүртэлх хугацаанд иргэд болон ойн нөхөрлөлүүдтэй хамтран эргүүл, хяналт шалгалтыг зохион байгуулах.

2.2 Ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, сургалт сурталчилгааг хүн бүрт хүргэж, аврах, гал унтраах бие бүрэлдэхүүнийг томилсон байх.

2.3 Ой хээрийн түймэр гарсан тухай болон түймэр унтраах ажлын явцыг сумын Засаг дарга болон Онцгой байдлын штабт шуурхай мэдээлэх, түймрийн шалтгаан, гаргасан этгээд, хохирлыг тогтооход эрх бүхий албан тушаалтанд дэмжлэг үзүүлж ажиллах.

Гурав. Албан газар, байгууллагын дарга, эрхлэгч нарт ДААЛГАХ нь:

3.1 Байгаль орчныг хамгаалах болон Ойн тухай хууль тогтоомж, Засгийн газар, Засаг даргын шийдвэр, байгаль орчны улсын байцаагч, Байгаль хамгаалагчийн шаардлагыг биелүүлж ажиллах.

3.2 Объектын болон ой, хээрийн түймэр унтраахад хүн хүч, тээврийн болон бусад хэрэгслийг гаргаж өгөх.

3.3 Түймрийн аюултай үе буюу хуурайшилт бүхий цаг хугацаанд ой, хээрт мод бэлтгэх, ойн дагалт нөөцийг ашиглах, аялал зугаалга хийх, зорчих, бусад үйл ажиллагааг явуулахгүй байх.

Дөрөв. Иргэн, айл өрхөд ДААЛГАХ нь:

4.1 Ойн баялгийг хууль бусаар ашигласан, гэмтээсэн, устгаж сүйтгэсэн зөрчлийн талаар тухайн шатны Засаг дарга, улсын байцаагч, байгаль хамгаалагчид нэн даруй мэдэгдэх.

4.2 Түймрийн аюултай үед ил задгай гал түлэхгүй байх, асаасан шүдэнз, татсан тамхины гал цог, нурмыг бүрэн унтрааж аюулгүй болгох.

4.3 Гэр, байшин, хураасан өвс, хашаа, саравчны эргэн тойронд түймрийн хамгаалалтын зурвас татах болон түймэр унтраах байнгын багаж хэрэгсэлтэй байх.

4.4 Өрх бүр үнс, нурмыг тусгайлан бэлдсэн таглаа бүхий нүх, саванд хийж, түймэр алдахгүй байх нөхцөлийг хангах.

Document-Zahiramg

6729010034

4.5 Объектын болон ой, хээрийн түймрээс амь бие, эрүүл мэнд, эд хөрөнгөө хамгаалах, түймэр унтраах анхан шатны арга ажиллагааг эзэмшсэн байх, хүүхдээ түймрээс сэрэмжлүүлж сургах.

4.6 Тээврийн болон өөрөө явагч хэрэгслийг галын аюулгүй төхөөрөмжөөр тоноглох, галын аюултай бодис, шатах тослох материалыг хадгалах горимыг чанд мөрдөх

4.7 Хуурай өвс, ургамлын хучаас хадлангийн талбай, өтөг бууцыг шатаахгүй байх.

4.8 Ой, хээрийн түймрийг унтраах ажиллагаанд иргэний журамт үүргийнхээ дагуу оролцох, ой хээрийн түймэр илрүүлсэн тухай мэдээллийг зохих шатны Засаг даргад болон сумын Онцгой байдлын асуудал хариуцсан штабт яаралтай мэдээлэх.

Тав. Сумын хэмжээнд ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах, ажлын хэсгийг багт ажиллах шатах тослох материалын зардлыг хянаж Засаг даргын нөөцөөс гаргахыг Санхүүгийн албаны дарга (А. Дэлгэрмаа)-д зөвшөөрсүгэй.

Зургаа. Гал түймрийн үед ажиллах ажлын хэсгийг 1 дүгээр хавсралтаар, багаж хэрэгслийн жагсаалтыг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

Долоо. Байгаль орчин, тогтвортой хөгжлийн бодлогын тасагт ДААЛГАХ нь:

7.1 Ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх зорилгоор тухайн бүс нутагт түймрийн аюултай үе буюу хуурайшилт бүхий цаг хугацаанд байгаль орчинтой харьцах тодорхой үйл ажиллагааг хязгаарлах, зогсоох.

7.2 Ой, хээрийн түймрээс хамгаалах үйл ажиллагааг зохион байгуулах арга хэмжээний сумын төлөвлөгөөг жил тутамд боловсруулан сумын Гамшгаас хамгаалах албаны дарга (Засаг дарга)-аар батлуулж, хэрэгжилтийг зохион байгуулах.

Найм. Сумын Засаг даргын дэргэдэх Цагдаагийн хэсэгт ДААЛГАХ нь:

8.1 Объектын болон ой, хээрийн түймрийн шалтгаан эзэн холбогдогчийг шуурай тогтоох.

8.2 Ой, хээрийн түймрийн аюултай үед ойд зорчих иргэд, тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг хориглох арга хэмжээ авах.

Ес. Энэ захирамж гарсантай холбогдуулан: "Ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх тэмцэх ажлыг эрчимжүүлэх тухай" сумын Засаг даргын 2023 оны А/33 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

Арав. Энэхүү захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг сумын Засаг даргын Тамгын газрын дарга, Онцгой байдлын асуудал хариуцсан штабын даргад үүрэг болгосугай.

ДАРГА

A red square official stamp of the Darhan-Uul Sum Citizens' Khural is centered on the page. Overlaid on the stamp is a handwritten signature in black ink. The signature appears to be 'Г. ОДСЭР'.

Г. ОДСЭР